



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№121 /335/

2022.07.06

Цаг үе, үйл явдал

“АЛДАР” СПОРТ ХОРООНЫ АХМАД ДАСГАЛЖУУЛАГЧ ОУХМ, ЧӨЛӨӨНД БАЙГАА ДЭД ХУРАНДАА Я.БААТАР “ГАВЬЯАТ ДАСГАЛЖУУЛАГЧ” ЦОЛООР ШАГНУУЛАВ



Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн зарлигаар Монголын дугуйн холбооны зөвлөх, БХЯ-ны харьяа Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны ахмад дасгалжуулагч чөлөөнд байгаа дэд хурандаа Янжингийн Баатарт Гавьяат дасгалжуулагч цолыг хүртээлээ.

Түүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс шагналаа аван гарч ирэхэд БХЯ-ны харьяа Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны алба хаагчид болон Монголын дугуйн

холбооны баг тамирчид угтан авч баяр хүргэлээ.

Ахмад дасгалжуулагч ОУХМ Я.Баатарын амжилтаас дурдвал

-1964 оны Токиогийн олимпод оролцогч, “Алдар” Спорт хорооны дугуйн багийг үндэслэгч, “Тегеран 1974” Азийн наадмын анхны хүрэл медалийн дасгалжуулагч

-1989-1990 оны Армийн аваргын багийн мөнгө, хүрэл медалийн дасгалжуулагч

-2022 Азийн аваргын Залуучуудын хүрэл медалийн дасгалжуулагч гээд бүтээсэн гаргасан амжилтуудыг дурдаад баршгүй юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 23 | 🌧️ 13 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 36 | 🌧️ 25 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|--------|----------|---------|
| USD 🇺🇸 | 3.173.00 | 3.180.0 |
| EUR 🇪🇺 | 3.260.0 | 3.290.0 |
| CNY 🇨🇳 | 472.00 | 475.00 |
| RUB 🇷🇺 | 48.50 | 52.00 |
| JPY 🇯🇵 | 23.00 | 23.30 |
| KRW 🇰🇷 | 2.38 | 2.42 |

ЗУРХАЙ



2022.07.06 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 7

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ЦАГААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.00-20.53

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

Суудал: Гал

Энэ өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, хур оруулах, дархны үйлд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогосод зүүн урд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗХЖШ-ЫН ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛЫН НЭГДСЭН БЭЛТГЭЛТЭЙ ТАНИЛЦАВ

Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улсын 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах “Төрийн далбааны өдөр”-т зориулсан Цэргийн ёслолын жагсаалд оролцох Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын бүрэлдэхүүн бэлтгэлээ базаасаар байна.

Энэ хүрээнд өнөөдөр өглөө үүрийн 04.00 цагт Сүхбаатарын талбайд удаах нэгдсэн бэлтгэл хийгдлээ. Нэгдсэн бэлтгэлийн үйл явцтай ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү болон Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, албаны бусад хүмүүс танилцав.

Энэ удаагийн “Төрийн далбааны өдөр”-т зориулсан Цэргийн ёслолын

жагсаалд БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ОБЕГ, ШШГЕГ, ТТХГ, ТЕГ, ЦЕГ, ДЦШ, ХЗЦК, АЦК, ТХЦК, ҮБХИС, ДХИС гэсэн 14 байгууллагын 4000 гаруй алба хаагч оролцож байгаа юм.

Цэргийн ёслолын жагсаалыг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, Улаанбаатар цэргийн хүрээний дарга бригадын генерал С.Ганбямба командлах бол тугийн чиглүүлэгчээр ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг, тугчаар Зэвсэгт хүчний ХШҮГ-ын дарга хурандаа Ж.Өсөхбаяр, тугийн хамгаалагчаар ЗХЖШ-ын Материал техникийн газрын Материал хангалтын төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа С.Баяр-Очир, Захирааны удирдлагын хэлтсийн дарга хурандаа Д.Номт нар ажиллах юм. Энэ жилийн “Төрийн далбааны өдөр”-ийн Цэргийн ёслолын жагсаал нь түүхэн ойнууд



давхацсан жилд зохион байгуулагдаж буйгаараа онцлог бөгөөд энэ хүрээнд Батлан хамгаалахын сайдын тушаалаар Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, “Төрийн далбааны өдөр”-т зориулсан Цэргийн ёслолын жагсаалд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас оролцох салбаруудын дунд “Тэргүүний жагсаалч удирдлага, байлдааны тугийн бүрэлдэхүүн”, “Тэргүүний жагсаалч салбар”, “Тэргүүний жагсаалч эгнээ”-г анх удаа шалгаруула. Энэ нь Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчин, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын

үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, Цэргийн ёслолын жагсаалын дүрэмч, жагсаалч, идэвх оролцоо, санаачилга, жигдрэлтийн байдлыг сайжруулах зорилготой юм. Мөн энэхүү цэргийн ёслолын жагсаал нь 4000 гаруй цэргийн алба хаагчаас гадна 300 гаруй нэгж техникийн парад, морин цэргийн парад зэрэг өргөн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулагдаж буйгаараа онцлог юм. Одоо нэгдсэн бэлтгэлийн хүрээнд 7 дугаар сарын 9-ний өдөр сүүлийн шөнийн цэргийн ёслолын жагсаалыг дахин зохион байгуулна.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 556,524,032

Эдгэрсэн

Нийт: 530,893,661

Нас барсан

Нийт: 6,364,661

Цахим шууданд

БӨРТЭ ТӨААТҮГ ОЛОН УЛСЫН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЛЭЭ



Цэргийн оёдлын үйлдвэр болох Бөртэ ТӨААТҮГ нь ISO 9001-2015 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэн албан ёсны гэрчилгээгээ гардан авчээ.

Тодруулбал, Бөртэ ТӨААТҮГ-ын Ерөнхий захирал, хурандаа Д.Энхтайванд ХБНГУ-аас Монгол улсад суугаа элчин сайд Ноён Jom Rosenberg ХБНГУ-ын DAKKS-ын итгэмжлэлтэй UNICERT-ээр баталгаажуулсан албан ёсны гэрчилгээгээ өчигдөр элчин сайдын яаманд гардуулан өгчээ.



ЦУГЛАСАН ХҮҮХЭД, ЗАЛУУСТ ЖАГСААЛЫН ҮЗҮҮЛЭХ ТОГЛОЛТЫГ ТОЛИЛУУЛЛАА



Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 7 дугаар сарын 04-ний өдрийг "Гэр бүлийг дэмжих өдөр" болгон зарлаж, аймгийн хэмжээнд хүүхэд, залуусын эрх хамгаалал, хүчирхийллээс ангид байлгах тухай уулзалт, сургалт болон сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг ч

явуулж байна. Энэ хүрээнд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагчид Төв аймгийн Зуунмод сумын төв талбайд цугласан хүүхэд багачууд, олон нийтэд жагсаалын үзүүлэх тоглолтыг толилуулж, цэргийн албаны онцлог, ач холбогдлын талаар ярилцлага өрнүүлээ.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулж буй энэхүү арга хэмжээ нь энэ өдөр "Тоонот" рекордсын үнэ төлбөргүй тоглолтоор үргэлжлэх бөгөөд хүүхэд залуусыг соён гэгээрүүлэх, хүүхдийн хүчирхийллийн эсрэг нэгдэхэд чиглэгдэж байгаа юм.

НААДМЫН СОРИЛГО, ШИНЭ ЗУРХАЙН НЭЭЛТИЙН ШАГАЙН ХАРВАА ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН ЯВУУЛЛАА



Тулгар төрийн 2231, Их Монгол улс байгуулагдсаны 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 111, Ардын хувьсгалын 101 жилийн ой, Үндэсний Их баяр наадмыг угтан наадмын сорилго, шинэ зурхайн нээлт, шагайн харвааны тэмцээнийг мотобуудлагын батальоны

бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулж явууллаа. Тэмцээнд нийт 7 багийн 49 тамирчин оролцож цэц мэргэнээ сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт ахлах ахлагч С.Сүхбаатар ахлагчтай баг, дэд байрт ахлагч С.Ганболд ахлагчтай баг, гутгаар байрт дэд ахлагч Б.Баяржавхлан ахлагчтай багууд тус тус

шалгарлаа.

Батальоны удирдлагын зүгээс нийт оролцсон баг, тамирчдаа Үндэсний их баяр наадмын тэмцээнд нь өндөр амжилт хүсэж, оноо нь мэргэн, хараа нь хурц, уухай нь цээл байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Ахлах дэслэгч П.БАЯЛАГМАА

"ОРОЛЦОО-2022" ТӨСӨЛ МАРГААШ ХААЛТАА ХИЙНЭ



Монгол Улсын Батлан хамгаалах яам, Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам зэрэг дөрвөн яамны хамтарсан "Оролцоо-2022" төсөл Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын баазыг түшиглэн амжилттай явагдаж байна. Төслийн хаалт маргааш

зохион байгуулагдах бөгөөд залуучуудад эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэх зорилготой юм.

Энэхүү төсөлд 18-34 насны 300 гаруй 18-34 насны залуус хамрагдаж,

ажил, амьдралынхаа гарааг зөв эхлүүлэх, зорилгоо тодорхойлох, өөрийгөө илэрхийлэх, хөдөлмөр эрхлэх чадвар, чиг баримжаа олж авахаас гадна эх оронч үзэл санаа, эрүүл зөв амьдралын хэв маяг, төлөвшил, гэр бүлийн утга учир, хамтын хүсэл мөрөөдөл, түүнд хүрэх арга замын талаар суралцсан юм.



ТҮРҮҮЧ Ц.БИЛЭГЖАРГАЛ ХҮССЭН СУРГУУЛЬДАА ТЭНЦЭВ



Зэвсэгт хүчний нэгтгэл, ангидын хугацаат цэргийн алба хаагчид цэргийн албыг хаангаа их, дээд сургуульдаа цахимаар суралцаж, элсэлтийн ерөнхий шалгалтад өөрийгөө бэлтгэж, хүссэн их, дээд сургуульдаа элсэх боломж байдгийг цөөнгүй

түрүүч, байлдагч нар үлгэрлэн харуулсаар байна. Үүний нэг нь Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагч, түрүүч Ц.Билэгжаргал бөгөөд тэрээр элсэлтийн ерөнхий шалгалт болон эрүүл мэндийн үзлэг, ур чадвараараа ч Дотоод хэргийн

их сургуульд тэнцэж, хүссэн мэргэжлээрээ суралцах боломжтой болжээ. Түрүүч Ц.Билэгжаргал нь Говь-Алтай аймгийн Төгрөг сумаас хугацаат цэргийн албанд татагдсан ба албаа нэр төртэй хааж дуусгаад, сургуульдаа элсэн суралцах юм байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАН НААДАЦГАА

Харуул, хоногийн манааны бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлт, сонор сэрэмжийг дээшлүүлэх

Ил задгай газраас хоол хүнс худалдан авахгүй байх, Ковид-19 болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх

Баяр, амралтын өдрүүдээр мэдээлэл, соёл хүмүүжлийн ажлыг осол авааргүй зохион байгуулах

Түлсэн гал, асаасан шүдэнз, татсан тамхины цог, үнс нурмыг бүрэн унтраах

Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ханган, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сахих хөдөлгөөнд оролцох

Үер, усны аюулаас болгоомжилж, гол, мөрний ойр орчимд бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх

Архи, согтууруулах ундааны зүйлийг зөв зохистой тохируулан хэрэглэх

Хэт халалтын үед наранд цохиулахаас урьдчилан сэргийлэх